

2023 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,  
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2023.03.20

Өлзийт сум

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	ЗДТГазар	2	2	-	-	-	100%
2	Эрүүл мэндийн төв	1	1	-	-	-	100%
3	ЕБСургууль	2	-	-	-	2	-
4	Цэцэрлэг	1	1	-	-	-	100%
5	Нийгмийн даалтгал	33	33	-	-	-	100%
6	Мал эмнэлгийн тасаг	4	4	-	-	-	100%
7	Багийн Засаг дарга нар	6	6	-	-	-	100%
8	Хөдөө аж ахуйн тасаг	5	-	-	-	5	-
<b>НИЙТ ДҮН</b>		<b>54</b>	<b>47</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>87%</b>

2023 ОНЫ 1-Р УЛИРАЛД ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД  
ХАНДАЖ ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ (ХЭЛБЭРЭЭР)

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдол санал хүсэлт	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	ЗДТГазар	2	2	-	-	-	-
2	Эрүүл мэндийн төв	1	1	-	-	-	-
3	ЕБСургууль	2	2	-	-	-	-
4	Цэцэрлэг	1	1	-	-	-	-
5	Нийгмийн даалтгал	33	33	-	-	-	-
6	Мал эмнэлгийн тасаг	4	-	-	2	2	-
7	Багийн Засаг дарга нар	6	-	-	6	-	-
8	Хөдөө аж ахуйн тасаг	5	1	-	2	2	-
<b>НИЙТ ДҮН</b>		<b>54</b>	<b>40</b>	<b>-</b>	<b>10</b>	<b>4</b>	<b>-</b>

## ӨРГӨДӨЛ ГОМДОЛ САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА (ХУВИАР)

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
1	Өлзийт сум	Өргөдөл – 40	40/ 74%		
		Хүсэлт – 10	10/ 18,6 %/		
		Санал - 4	4/ 7,4%/		
		Талархал - 0	0/ 0%		
		Гомдол – 0	0/ 0%/		
		<b>Асуудлын нэр</b>	<b>Нийт тоо</b>	<b>Нийт хувь</b>	
		Төрийн байгууллагад ажилд орох, чөлөөлөгдөх, эхийн чөлөөний хүсэлт	6	11,1%	
		Нийгмийн даалтгалын тэтгэвэр, тэтгэмж	33	61,1%	
		Хоршоо хөгжүүлэх сангаас зээл хүссэн	5	9,2%	
		Сумын төрийн байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдээс нийтийн эзэмшлийн талбай, бүх нийтийн хогийн цэвэрлэгээ, нэгдсэн халаалттай холбоотой	6	11,1%	
		Малын гоц халдварт өвчин, эрүүл мэндийн дуудлага, үйлчилгээ	4	7,5%	
		<p>2023 оны 1-р улирлын байдлаар 54 санал, хүсэлт, өргөдөл ирж</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шийдвэрлэсэн – 47</li> <li>• Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа – 7</li> <li>• Шийдвэрлэлт – 87 хувьтай.</li> </ul>			

**Төрийн үйлчилгээг хүргэх чиглэлээр:**

- Байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу: Сумын төвийн нэгдсэн халаалтын талаар “Ган-Илч” ХХК-д уламжилж, галлагаанд хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч ажилласан.
- Албан байгууллага аж ахуйн нэгжүүд, болон гэр хорооллын айл өрхүүд бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа хийж 4 тн хогийг нэгдсэн цэгт төвлөрүүлээ.
- Тагт багийн Баюун, Хар-Овоо, Дэрт багийн Дэрсэнэ-Ус гэх газруудад малын гоц халдварт мялзан өвчний голомт үүсч Сумын Засаг даргын захирамжаар 21 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоож байнгын хяналтын пост ажиллуулж, хориотой бүс нутгийн малчдад малын эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн.
- 2023.03.09-03.10-нд болсон хүчтэй шороон шуурга цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ, мэргэжлийн байгууллагуудын заавар, зөвлөмжийг сумын цахим хуудсанд байршуулж, 506 өрхийн гар утсанд мессеж илгээж малчид, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан.
- Шороон шуурганд өртөж орон гэр нь нурсан 6 өрхийн мэдээлэл, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн Аймгийн Онцгой байдлын газарт уламжилсан.
- Гурвансайхан сумын Ширээгийн зоо гэх газарт отроор явж байгаа Буянт 2 дугаар багийн малчин Т.Ариунжаргалын 200 гаруй мал элс шороонд дарагдаж, Засаг даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг газар дээр нь очиж, хорогдсон малын сэг зэмийг ачиж, нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан.

**Хүлээгдэж буй өргөдлийн талаарх шалтгаан:**

- 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Сумын ИТХ-ын 69 дүгээр тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сангийн Тэргүүлэх чиглэл, Төсөл сонгон шалгаруулах хороо, Хяналтын зөвлөл, Зээл сонгон шалгаруулах товыг хэлэлцэн батлуулсан.
- Тус тогтоолоор зээл олгох товыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр тогтоосон.
- 2023 оны 03 дугаар сарын 20-ноос 04 дүгээр сарын 20-ныг хүртэл төслийг хүлээн авч 05 дугаар сарын 01-нд төслөө сонгон шалгаруулахаар төлөвлөж байна.

ТАЙЛАН ГАРГАСАН: БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН А.ТҮМЭНДЭМБЭРЭЛ